



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар

А/66

Амардалтай

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "ж, л", 31 дүгээр зүйлийн 31.1.6 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд худалдаа үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгжүүд сар бүрийн 15 ны өдөр амарч, 5, 25 ны өдрүүдэд 08.00-18.00 цагийн хооронд ажиллаж, дээрх 3 өдөрт архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг хориглосугай.
2. Аж ахуйн нэгжийн ажиллах цагийн хуваарийг 06, 07-р сард 08.00 цагаас оройн 21.00 цаг, 08-09-р сард 08.00-20.00 цаг хүртэл ажиллуулсугай.
3. Ард иргэдийн үйлчлүүлэх тав тухтай орчныг бүрдүүлж, өөрийн байгууллагын гадна, дотно орчныг сайжруулж, хогийн савыг байршуулж, нийтийг хамарсан их цэвэрлэгээний үед худалдаа үйлчилгээ явуулахыг түр хугацаагаар зогсоож, өөрийн аж ахуйн нэгжийн ойр орчмоос 50 метр хүртэлх газрыг 7 хоног бүр цэвэрлэж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аж ахуйн нэгжийн дарга, удирдлагуудад даалгасугай.
4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (Л.Отгонбаатар), хэсгийн цагдаа (Т.Содбилэг), Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Энхдэлгэр) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ

488010-239

